




ТӨРИЙН БАНКНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН



■ АГУУЛГА

БИДНИЙ ТУХАЙ

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Компанийн засаглал


БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

ХАМТЫН АЖИЛЛАГАА

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ



■ БИДНИЙ ТУХАЙ



Монголбанк нь Монгол Улсын Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 тоот тушаалаар батлагдсан “Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам”-ыг үндэслэн Төрийн банканд 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр “26” дугаар бүхий БАНКНЫ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ олгосон болно.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны хуулийн хэрэгжилтийг хангаж, банкны системд нөлөө бүхий банкуудаа манлайлан Төрийн банк хувьцаагаа “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан олон нийтэд санал болгож анхдагч зах зээлийн арилжаанд нийт хувьцааны 5.71 хувийг гарган, 25.4 тэрбум төгрөгийг 7421 хувьцаа эзэмшигчдээс амжилттай татан төвлөрүүлж хөрөнгийн зах зээлийн түүхэнд нэгэн шинэ хуудсыг нээн, нээлттэй хувьцаат компани болсон.

Төрийн банк нь олон улсын стандартад нийцсэн орчин үеийн банк, санхүүгийн цогц үйлчилгээг орон даяар саадгүй хүргэх, бүх талын хамтын ажиллагааг дээдлэх, харилцагчдынхаа бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн олон талт хэрэгцээг хангахад чиглэн Монгол орон даяар 495 салбар нэгж, 328 АТМ, 6420 картаар үйлчлэгч байгууллагаар дамжуулан үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Төрийн банк нь 4.2 их наяд төгрөгийн актив хөрөнгөтэй, өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон бусад үзүүлэлтээрээ Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллаж байна. Төрийн банк нь банкны салбарын зохистой бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн, Монгол Улсын банкны салбарын ТОП 5 банкны нэгээр дахин шалгарч, амжилтаа баталгаажууллаа.

АЛСЫН ХАРАА

Дундаж давхаргыг дэмжигч, үндэсний тэргүүлэгч банк байна.


ЭРХЭМ ЗОРИЛГО

Харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжих, бойжуулахад чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлнэ.





■ ТӨРИЙН БАНКНЫ ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ:



Цахим болон бусад үйлчилгээ



↗ **599,826**

Гялсбанкны харилцагч



↗ **6,420**

Картаар үйлчлэгч
байгууллага



↗ **40**

Киоск төхөөрөмж



↗ **84,416**

Иж бүрэн даатгал



↗ **950**

Ухаалаг ПОС

2022 он




Банкны активын чанар, эрсдэлийн сан, өөрийн хөрөнгийн хүрэлцээг тогтоох, гадаад, дотоод оролцогч талуудыг бодит, ил тод мэдээллээр хангах зорилгоор Монголбанк болон хараат бус, Олон Улсын хөндлөнгийн аудитын байгууллагаас “Активын чанарын үнэлгээ” хийж, санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу активын эрсдэлийн санг бүрэн байгуулсан, өөрийн хөрөнгийн хүрэлцээг ханган ажиллаж буйг баталгаажуулсан.

Төрийн банк 2022 онд системийн нөлөө бүхий банкуудаас хувьцаагаа анхлан олон нийтэд санал болгож, татан төвлөрүүлсэн хөрөнгийн 50 хувийг тогтвортой хөгжил болон дундаж давхаргад чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тус тус зарцуулан ажиллалаа.



ТОП-100 аж ахуй нэгжээс наймдугаарт, банкны салбарын шилдэг дөрвөн банкны нэгээр дахин шалгарлаа.



Монгол Улсын нийгэм эдийн засагт хувь нэмэр оруулан Сангийн яам, Татварын ерөнхий газрын талархлыг хүртэв.



“Дэлхийн мөнгөний долоо хоног 2022” аянд оролцож дэд байр эзлэн хүндэт цомын эзэн боллоо.

■ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм харилцагчид, хувьцаа эзэмшигчид, бизнесийн хамтрагчид та бүхэндээ Төрийн банкны хамт олны 2022 он хүртэл хийж бүтээсэн Тогтвортой хөгжлийн ажлын тайланг танилцуулж байгаадаа баяртай байна. Төрийн банк нь улсын хэмжээнд 495 салбар, нэгж, 4000 гаруй ажилтнаараа дамжуулан санхүүгийн цогц, хүртээмжтэй үйлчилгээг харилцагч нартаа хүргэн ажиллаж байна.

Төрийн банк 2015 оноос эхлэн ТоС хөтөлбөр болон Тогтвортой санхүүжилтийн холбоонд элсэн орж байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлэхээс эхлэн Тогтвортой хөгжлийн 17 зорилгод үйл ажиллагаагаа нийцүүлэн, хувь нэмрээ оруулан ажиллаж ирлээ.

Бид анх 2015 онд “Байгаль орчин, нийгмийн бодлого, журам”-аа батлуулан хэрэгжүүлж ирсэн бөгөөд тасралтгүй сайжруулж, 2022 онд “Байгаль орчин,

нийгэм, засаглалын бодлого”-ын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх холбогдох журам, зааврыг шинэчлэн баталлаа. Мөн тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг онцгойлон анхаарч, банканд “Тогтвортой хөгжлийн хороо” болон “Тогтвортой хөгжлийн алба”-г шинээр байгуулж, энэхүү үйл ажиллагааг банкны бүхий л түвшинд хэрэгжүүлэх зорилго бүхий Тогтвортой хөгжлийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэн, чиглэл тус бүрт анхааран ажиллаж байна.

Банкны Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого нь Олон улсын болон Монгол Улсын Тогтвортой хөгжил болон байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээрх бодлогын бичиг баримтуудтай уялдаж гарсан бөгөөд банк урт хугацаанд тогтвортой хөгжихийн тулд байгаль орчин, нийгэмд ээлтэй, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг дэмжих, зохистой засаглалын тогтолцоог хангаж ажиллах Тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн бүтээгдэхүүний хувьд 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувьд хүргэж ажиллах зорилгыг дэвшүүлээд байна.

Монголын Тогтвортой Санхүүжилтийн холбоо, Монголбанк, Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран “Тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийн үнэлгээ”-г 2016 оноос эхлэн жил бүр гишүүн байгууллагууддаа хийж ирсэн бөгөөд Төрийн банк ХК нь 2022 онд өмнөх оны үр дүнгээ ахиулан “А” буюу “Бүрэн тогтолцоотой” /Consolidating/ үнэлгээ авлаа.

Төрийн банканд итгэл үзүүлж хамтран ажилладаг нийт харилцагч, хамтран ажиллагч байгууллагууд та бүхэндээ талархал илэрхийлэн, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн:

Ө.ГАНТӨР

ТӨРИЙН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

■ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төрийн банк нь Компанийн зохистой засаглалын хэм хэмжээ, стандартыг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэнэ бүтээхийг зорин ажилладаг.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай уялдуулан хэрэгжилтийг хангаж Төрийн банк ХХК-ийг нээлттэй хувьцаат компани болгох ажлын хүрээнд 2022 оны 10 дугаар сард үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд нийт хувьцааны 5.71 хувийг гарган, 25.4 тэрбум төгрөгийг 7,421 хувьцаа эзэмшигчдээс амжилттай татан төвлөрүүлж, нээлттэй хувьцаат компани болсон.

Төрийн банк нь компанийн засаглалыг илүү сайжруулан, сайн туршлагыг нэвтрүүлэх хүрээнд 2023 оны 1 дүгээр улиралд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Засаглалын алба байгуулсны зэрэгцээ Тогтвортой хөгжлийн алба болон Тогтвортой хөгжлийн хороог шинээр бий болгон ажиллаж байна.

Төрийн банкны нийт хувьцааны 49.26 хувийг Төрийн захиргааны төв байгууллага, 45.03 хувийг Хадгаламжийн даатгалын корпораци, 5.71 хувийг олон нийт эзэмшиж байна.



Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

Төрийн банкны ТУЗ нь есөн хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөлөл болон хараат бус гишүүдтэй ажиллаж байна.

Төрийн банкны Төлөөлөн Удирдах зөвлөлийн ажиллах журмын дагуу ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлыг тогтмол зохион байгуулж, хурлаар банкны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, гүйцэтгэх удирдлагыг томилох, банкны жилийн стратегийг тодорхойлох, зохистой засаглалын болон эрсдэлийн удирдлагын бодлого, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлттэй танилцах, батлах, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Банкны тухай хуулийн 33.6 дахь заалт, Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл нь эрх үүргээ хэрэгжүүлэх үүднээс ТУЗ-ийн дэргэдэх хороод үйл ажиллагаагаа явуулдаг.



АУДИТЫН ХОРОО

Аудитын хороог ТУЗ-ийн Хараат бус гишүүн даргалдаг. Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, ТУЗ-өөс баталсан стратеги төлөвлөгөө, бодлогын хэрэгжилт, банкны үндсэн үйл ажиллагааны явцад хийгдэх гүйцэтгэлийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох асуудал, түүний үнэн бодит байдалд хяналт тавих, банкны дотоод болон хөндлөнгийн аудитын цар хүрээг тодорхойлох, үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх, аудитын хараат бус байдлыг баталгаажуулах чиглэлээр ажилладаг.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО


Эрсдэлийн удирдлагын хороог ТУЗ-ийн гишүүн даргалдаг. Банкны үйл ажиллагаанд үүсэж болох эрсдэлийн түвшнийг тодорхойлох, илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгахад шаардлагатай арга хэмжээг авах зэргээр оновчтой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг үнэлэх чиглэлээр ажилладаг.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО





Нэр дэвшүүлэх хороог ТУЗ-ийн Хараат бус гишүүн даргалдаг. Банкны залгамж халааны бодлогыг тодорхойлох, банкны Хяналтын зөвлөлийн гишүүн, эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, ажлын гүйцэтгэлд үнэлэлт өгөх, банкны эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлагын талаар дүгнэлт гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бие даасан, хараат бус байдлыг тогтоох, тэдгээрийг сургах, мэргэшүүлэх болон хувьцаа эзэмшигчдэд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, чөлөөлөх зэрэг асуудлаар мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажилладаг.

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО


Цалин урамшууллын хороог ТУЗ-ийн Хараат бус гишүүн даргалдаг. Цалин урамшууллын хороо нь банкны Хяналтын зөвлөл, ТУЗ-ийн гишүүд, банкны эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын бодлогыг тодорхойлох чиглэлээрх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.



ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТИЙН
8
ЗАРЧИМ



НҮБ-ЫН
ДАЯН ДЭЛХИЙН
ГЭРЭЭНИЙ
10
ЗАРЧИМ



■ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО



Банкны Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого нь Олон Улсын болон Монгол Улсын Тогтвортой хөгжил болон байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээрх бодлогын бичиг баримтуудтай уялдаж гарсан бөгөөд банк урт хугацаанд тогтвортой хөгжихийн тулд байгаль орчин, нийгэмд ээлтэй, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг дэмжих, зохистой засаглалын тогтолцоог хангаж ажиллах Тогтвортой хөгжилд чиглэсэн зээлийн бүтээгдэхүүний хувьд 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувьд хүргэж ажиллах зорилтыг дэвшүүлээд байна.



Бид санхүүжилтийн хөшүүргийг ашиглах замаар Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенцийн Парисын хэлэлцээрийн дагуу хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах, түүнд дасан зохицох үндэсний зорилтод хувь нэмрээ оруулах юм.



Үүн дотор, хүлэмжийн хийг бууруулах зорилгын хүрээнд сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй технологийг дэмжих, хөдөө аж ахуйн салбарт малын чанар, ашиг шимийг сайжруулахад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан дэмжлэг үзүүлнэ.






Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилтын хүрээнд усыг хэмнэх, саарал усыг ашиглах, химийн бодисын хэрэглээг бууруулах, хатуу хог хаягдлыг бууруулах болон эрчим хүчний хэрэглээг бууруулах чиглэлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.



Банкны тогтвортой хөгжлийн зорилт:

Бид 2023 онд тогтвортой хөгжлийн чиглэлээр мэргэжлийн байгууллагаас зөвлөх үйлчилгээ, техникийн туслалцаа авах, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, ногоон болон тогтвортой хөгжлийн таксономид нийцүүлэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, нөхцөл шаардлагыг харилцагчийн хэрэгцээнд нийцүүлэхийн зэрэгцээ банкны хүлэмжийн хийн ялгарлыг тооцох зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.





■ ХАМТЫН АЖИЛЛАГАА, АМЛАЛТУУД



Гадаад хамтын ажиллагаа:

- Төрийн банк нь БНХАУ, Япон, ХБНГУ, ОХУ, БНСУ, Сингапур зэрэг 6 орны олон улсын банк, санхүүгийн системийн хэмжээнд нөлөө бүхий 15 банктай корреспондент харилцаатай ба худалдааны санхүүжилтийн зээлийн шугамаар Тайванийн Экзим банк, олон улсын Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйлчилгээгээр Euroclear банктай, Олон улсын зах зээл дээр гадаад валют, үнэт цаас, хувьцаа, үнэт металлын арилжаанд зуучлах брокерын үйлчилгээгээр Saxo банктай тус тус хамтран ажилладаг.

Гадаад санхүүжилтийн чиглэлээр Нидерландын Frontclear, Олон улсын банк болох International Bank for Economic Co-operation болон Америкийн Нэгдсэн Улсын Cargill Financial Services International Inc байгууллагатай хамтран ажиллаж санхүүжилтийг амжилттай татаад байна.

- Төрийн банк нь Нидерландын Вант улсын Frontclear олон улсын санхүүгийн байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, дөрөв дэх удаагийн репо хэлцлээр 23.0 сая ам.долларын бага хүүтэй хямд эх үүсвэр амжилттай татлаа. Энэхүү репо санхүүжилтийг авснаар бид бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих бизнесийн зээл, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны зээлийг тус тус шинээр гаргаж, зээлийн бүтээгдэхүүний хүүгээ бууруулж ажиллалаа.



frontclear
A financial markets development company

- Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк (International Bank for Economic Co-operation)-аас 11.0 сая ам.долларын эх үүсвэрийг хадгаламжаар татан төвлөрүүлэв.



- Төрийн банк жижиг, дунд бизнес эрхлэгчдийн экспорт, импортын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бизнесээ өргөжүүлэхэд нь туслах зорилгоор АНУ-ын Олон Улсын байгууллага (Cargill Financial Services International Inc)-аас гадаад худалдааг дэмжих 25 сая ам.доллар буюу 87 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 2023 онд амжилттай татан төвлөрүүллээ. Тус эх үүсвэрийг татсанаар харилцагчдадаа эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалт, зээлийн шугам, худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн үйлчилгээг илүү өргөн хүрээнд үзүүлэхэд томоохон түлхэц болох юм.



- Тайванийн Экспорт-Импортын банкнаас баталсан 2.0 сая ам.долларын дамжуулан олгох зээлийн шугамыг сунгаж, холбогдох гэрээг шинэчлэн байгуулав.



- Moody's байгууллагаар Зээлжих зэрэглэлийн нөлөөллийн оноо (ESG Credit Impact Score)-г тооцуулж, CIS-2 Сөрөг нөлөөлөл бара (Neutral-to-Low) үнэлгээ авсан.




INTERNATIONAL FX TRADE



INTERNATIONAL MONEY TRANSFER







Дотоод хамтын ажиллагаа:



Бид 2013 оноос Монголын Тогтвортой санхүүжилтийн (ТоС) хөтөлбөрт нэгдэж, 2018 оноос Монголын Тогтвортой Санхүүжилтийн холбооны гишүүн байгууллага болон элсэж, банкн дотроо ТоС-ийн ажлын хэсгийг байгуулан ажиллаж

эхэлсэн билээ. Үүнээс хойш холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн бөгөөд ТоС холбооны дэргэдэх БОНЗ, уур амьсгалын эрсдэлийн мэргэжлийн зөвлөл, Ногоон зээлийн бодлого, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн мэргэжлийн зөвлөлд тус тус гишүүд болон даргаар идэвхтэй хамтран ажиллаж байна.



Гэр хороололд гал түлэхгүй, утаагүй, урсгал зардалгүй, дулаахан тухтай амьдрах боломжтой технологийн шийдлийг илүү сонирхолтой шинэлэг хэлбэрээр иргэдэд таниулах зорилгоор “Дулаан хамгаалдаг байшин” контентийг МООД, Хайбрид хаус

ХХК, Сакура пропертиз ХХК-ийн хамт олонтой хамтран бэлтгэж 1.2 сая үзэгчид хүргэлээ.



Дээрх контентын дараагийн үе шат болгож Шинэчилгээ төсөл Монгол ТВ болон Хайбрид хаус ХХК хамтран агаарын бохирдол, дулаан, цахилгаан гэр хороолол, түгжрэл гэх асуудлын шийдлийг энгийн сонирхолтой байдлаар олон нийтэд хүргэж,

мэдлэгжүүлэх зорилготой “Шинэчилгээ” нэвтрүүлэг бэлтгэх, ингэхдээ эрчим хүчний хэмнэлттэй дулаанаа хамгаалдаг байшинг олон нийтийн хамтралаар барьж тохижуулан олон нийтэд нээлттэй үзүүлэнгийн байшин болгох зорилгод Төрийн банк нэгдэж, хамтран ажиллаж байна.



Амлалтууд:



Бид Нэгдсэн Үндэсний Байгууллагын дэргэдэх Global compact буюу Даян дэлхийн гэрээнд үүрэг амлалт аван нэгдэх болсон бөгөөд гишүүн болсноор Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэн, стратегийн арга хэмжээ авч, үйл ажиллагааг тогтоосон 10 зарчмуудтай уялдуулж хариуцлагажуулах чухал зорилготой юм. Уг гэрээнд 160 гаруй улс орны 15,000 гаруй бизнесийн байгууллага, 3,800 гаруй бизнесийн бус байгууллагууд тус тус нэгдсэн байна.



2022 онд Монголын тогтвортой санхүүгийн замын зургийг баталсны дотор 2030 онд банкны салбарын ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх зорилт тавьсантай ижил зорилгыг Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогодоо тусган, бизнес төлөвлөөний зорилт болгон хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин ажиллаж байна.



■ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Тогтвортой ажлын байр



Ажилтнуудын оролт, гаралтын хөдөлгөөнийг зохистой түвшинд барих, чадварлаг мэргэшсэн боловсон хүчнийг тогтоон барих, ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ажилтны ажлын гүйцэтгэл, мэдлэг ур чадвар, туршлага, ажлын байрны онцлогт тохирсон цалин хөлсийг олгох замаар цалин хөлсний системийг сайжруулан үндсэн цалинг нэмэгдүүлэх, улирлын урамшуулал олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

2022 онд 30 ажлын байрыг дотооддоо шилжүүлэх болон шинээр бий болгох замаар нэмэгдүүлж ажиллалаа.



Ур чадвартай ажилтныг нээн илрүүлж, ажилтнуудын карьер хөгжлийг дэмжиж, тасралтгүй сургаж хөгжүүлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байна.



Банкны залгамж халаа болох ур чадвартай ажилтнуудыг нээж илрүүлэх зорилго бүхий “Талант менежмент” уралдааны цар хүрээ, ач холбогдлыг өргөжүүлэн 24 аймаг, 7 дүүргийн хэмжээнд амжилттай зохион байгуулж, ур чадвартай ажилтнуудаа алдаршуулж урамшууллаа.



Ажилтнуудыг эрхэлж буй ажил үүргээ гүйцэтгэхэд мэргэшил дээшлүүлэх, мэргэжил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлж 20 ажилтанд сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг олголоо.



Их, дээд сургуулийн оюутан залууст практикт суурилсан ажлын бодит туршлага хуримтлуулж, ажлын гарааны суурийг цогцоор нь зөв эхлүүлэх боломжийг олгож цалинтай дадлагажуулах хөтөлбөрийг Санхүү эдийн засгийн их сургууль болон Отгонтэнгэр их сургуультай хамтран хэрэгжүүлж 12 оюутныг цалинтай дадлагажууллаа.



Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ажилтнуудыг идэвхжүүлэх, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүллээ.



Ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтыг Хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, ажилтнуудыг зайнаас ажиллуулж эхэллээ.



Ажилтны нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн “Манлайлагч хамт олон шалгаруулах уралдаан”-ыг ажлын цаг ашиглалт, ажил үүргийн биелэлт, хамт олны, багийн арга хэмжээ, эерэг хандлага түгээх контент, сайн сайхны төлөөх арга хэмжээ, асуулт хариултын тэмцээн гэсэн агуулгуудын хүрээнд зохион байгуулж, шалгарсан хамт олныг урамшууллаа.



Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж 200 ажилтанд ажилтны орон сууцны зээлийн эрх олголоо.



Хамт олноо манлайлан ажилласан 840 ажилтныг Засгийн Газар, салбар яамд болон Төрийн банкны дотоод шагналуудаар шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулж, 2022 оны тэргүүний 60 ажилтныг шалгаруулж, урамшууллаа.



Нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд тогтмол хамруулдаг бөгөөд 2022 онд 2,849 ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан. Мөн бүх ажилтнуудаа эрүүл мэнд, эм, эмчилгээний даатгал болон мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулсан.



Банк нь ажилтнуудын өдөр тутмын эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулан банкны үндсэн орон тоо бүхий эмчтэй ажиллуулж байна.



Банкны Спорт хорооны зүгээс бүх төрлийн спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна.




Банкны хэмжээнд нийт 80 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үндсэн орон тоонд ажиллуулж байна.




Банкны ажилтнуудаас ирсэн санал, гомдлыг “Төрийн банкны ажилтнаас гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам” болон шинээр байгуулагдсан “Маргаан таслах комисс”-ын дагуу түргэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна.





Ажилтны сургалт, хөгжлийн чиглэлээр



Банк нь ажилтнуудаа тасралтгүй хөгжүүлэх, чадавхжуулах, чиглэл тус бүрд мэргэшсэн хүний нөөцийг бий болгох хүрээнд мэдлэг мэдээлэл, хүртээмжтэй сургалтыг түгээх зорилгоор e-learning цахим сургалтын системийг нэвтрүүлэн танхим болон цахим хосолсон сургалтын системийг амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна.

Сургалтын нэгдсэн программын хөгжүүлэлт, сайжруулалтыг хийж ажилтнуудын зайнаас суралцах боломжийг нэмэгдүүлэн, сургалтын материалыг цахимжуулах, цахим контент бэлтгэх ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж, нийт ажилтнуудын 74 хувийг цахим сургалтад хамруулаа. Мөн бүсчилсэн сургалтыг анх удаа танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, нэгжийн гүйлгээний ажилтнууд болон харилцааны менежерүүдийн 44 хувийг хамруулаа.

Гадны байгууллагын сургалт, хөтөлбөрийн хүрээнд:

Европын холбооны Erasmus+ хөтөлбөрийн дагуу Монгол улсад хэрэгжиж буй “Монгол улсын дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлэн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” / MONGWBL/ төслийн хүрээнд ХБНГУ-ын Берлин хотын Эдийн засаг, хуулийн их сургуульд чадавх бэхжүүлэх ээлжит сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа.



Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилттэй “Бэлэн байдлын хөтөлбөр”-ийн хүрээнд Франкфуртын их сургуулийн 6 сарын хугацаатай, сертификаттай мэргэшүүлэх сургалтад ажилтнаа хамруулж, “Certified expert in sustainable finance” сертификатаа авлаа.



ТоС Холбоо, Азийн сан байгууллагаас санаачилж, Монгол Улсын Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран анх удаа хэрэгжүүлж буй “Women in Finance” санхүүгийн салбарын эмэгтэйчүүдийн манлайлын хөтөлбөрт Төрийн банкнаас төлөөлөл оролцож хөтөлбөртөө амжилттай хамрагдаж байна.

Тогтвортой Санхүүжилтийн чиглэлээр Олон улсын туршлага судлах аяллыг Герман, Нидерланд улсуудад зохион байгуулж, ТоС Холбооны гишүүн байгууллагууд, Олон Улсын Санхүүгийн Корпораци, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо,



Монголын Банкны Холбоо, Банк, санхүүгийн академи болон ТоС холбооны нийт 34 төлөөлөл оролцсон бөгөөд Төрийн банкнаас төлөөлөл оролцон туршлага судлав.

Дотоодын сургалтын хүрээнд:



Тогтвортой хөгжлийн зорилт, Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, Тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн болон Тогтвортой санхүүжүүлэлтийн хөтөлбөрийн талаарх сургалтыг танхимаар болон цахим хэлбэрээр банкны нийт 2,214 ажилтанд хүргэж ажиллалаа.



Банкны урилгаар ТоС холбооноос “Тогтвортой санхүүжилт”-ын сүүлийн үеийн чиг хандлагын талаарх сургалтыг банкны нийт удирдах ажилтнуудад авсан бөгөөд банкны газар, хэлтсийн захирал, албаны менежер нийт 47 удирдах ажилтныг хамруулсан.



Улаанбаатар, орон нутгийн нийт давхардсан тоогоор 2,105 харилцааны менежер, зээл судлах чиг үүрэг бүхий нэгжийн захирлуудад “Байгаль орчин, нийгэм, жендерийн эрх тэгш байдлын бодлого, журам”-ын талаар мэдлэг, ойлголтыг түгээсэн.



Монголбанкнаас арилжааны банкны ажилтнуудад мэдээлэл өгөх зорилгоор зохион байгуулагдсан “Банкны ажилтнуудын семинар”-ын хүрээнд ТоС-ийн талаар ерөнхий ойлголтууд (тайлагнал, таксономи), Олон улсын туршлага, Монгол улс дахь хэрэгжилтийн талаарх сургалтад Банкны төв, Улаанбаатар, орон нутгийн нэгжийн 61 ажилтныг хамруулсан.



Банкны тогтвортой хөгжлийг хангах, тасралтгүй үйл ажиллагааг явуулах, мэргэшсэн банкир бий болгох зорилгоор Германы Шпаркассэ банктай хамтран “Мэргэшсэн банкир онол практик хосолсон сургалт”-ыг 2022 оноос Улаанбаатарын салбар нэгжийн 81 ажилтныг 11 төрлийн модуль хичээлд хамруулж байна.



Банкны бизнесийн стратеги зорилтыг дэмжих, тогтвортой хөгжлийг хангах, сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, зайнаас суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор 2022-2023 онд нийт 8 подкаст, 24 видео хичээлийг тус тус боловсруулан сургалтын програмдаа байршуулан нийт ажилтнуудын 74 хувийг хамруулан сургаж байна.

Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр:




Банкны мэдээллийн системийн аюулгүй байдал, хэвийн найдвартай ажиллагааг хангах, банканд дахь харилцагчдын

мэдээллийн нууцлалтай бүрэн бүтэн байдлыг Монгол Улсад мөрдөж буй хууль болон төв банкны шалгуурт нийцүүлэн хангаж үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан.



Төлбөрийн картын системийн нууцлалын стандарт болох PCI-DSS стандарт хангуулах олон улсын аудитын ажлыг Viking Cloud

LLC компаниас Төрийн банкны үйл ажиллагаанд хийж ажилласан ба Төрийн банк нь холбогдох аудитын стандарт, шаардлагуудыг бүрэн биелүүлж, холбогдох тайлангууд, сертификатыг хүлээн авч Visa International болон JCB International байгууллагуудад илгээн ажилласан.



Монголбанкны Арилжааны банкны Мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн журмын дагуу банканд COBIT аудитыг

7 процессийн хүрээнд хийлгэн, аудитын тайланг Монгол банканд хүргүүлэн, зөвлөмжийн дагуу ажлууд төлөвлөн ажиллаж байна.



Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ашиглагдаж буй сервер, системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг ханган

хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан дагуух систем, тоног төхөөрөмжийн шинэлэлтийг хийж мэдээллийн аюулгүй байдлын өдөр тутмын үйл ажиллагааг хангаж ажиллаж байна.

Ногоон оффис

Банкны Улаанбаатар, орон нутгийн 495 салбар нэгжээр дамжуулан цахим үйлчилгээг харилцагчдад түлхүү ашиглахыг санал болгосноор өнгөрсөн жилд цаасан маягтын зардлыг 12 хувиар, принтер болон хувилагчийн хорны зардлыг 10 хувиар тус тус бууруулж ажиллав.

Ногоон Худалдан авалтыг дэмжиж 2022 онд нэг дор олон үйлдэл багтаасан, унтрааж, амраах хэмнэлтийн горимын тохиргоо хийх боломж бүхий 1,850 ширхэг техник, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийж ажиллалаа.

Банкны төв оффисуудад дулааны хэрэглээг хэмнэх зорилгоор аж ахуй, засвар үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд гадна температур дулаан байгаа үед болон амралтын өдрүүдээр дулааны температурыг тохируулгаар багасган тохируулах, дулаан алдаж буй хаалга, цонхнуудын дулаалгыг хийн дулаан алдалтыг багасгах зэргээр хэмнэлтийг хийн ажиллаж байна.

Банкны төвийн цахилгаан эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэн хэмнэлт хийхээр оффиссын өрөөнүүдэд 242 ширхэг лэд гэрэл худалдан авч ажилласан ба цаашид бүх гэрлийг лэд гэрэлтүүлгээр жигдрүүлэн сольж дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

Ажилтнуудын ухамсарт хандлага, өдөр тутмын дадлыг хэвшүүлэхээр банкны үйл ажиллагаанд гарч буй хэрэглээний зардлуудад хэрхэн хэмнэлт хийх аргуудыг багтаасан мэдээлэл бүхий зурагт хуудсыг бэлтгэн, 7 хоног бүр тогтмол давтамжтайгаар цахим шуудангаар системийн хэмжээнд хүргүүлэн ажиллаж байна. Банкны төв оффис болон нийт нийт нэгжийн ажилтнуудад цайны цагаар гэрлээ унтраан, байгалийн гэрэлтүүлэг ашиглах хөдөлгөөнийг өрнүүлэн өдөр тутамд хэвшил болгон, цахилгааны зардлыг хэмнэн ажиллаж байна.

Улс орны хэмжээнд санхүүгийн хүндрэлтэй байдал үүсч төрийн байгууллагуудад хэрэгжүүлэх эдийн засгийн арга хэмжээний хүрээнд хэмнэлтийн горимд шилжин ажиллах үүрэг өгсөн ба Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан өдөр тутмын үйл ажиллагаанд ногоон менежментийг хийж, үргүй зардлуудыг тэвчин, төсөв төлөвлөгөөндөө хязгаарлалт хийж, өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад шаардагдах зайлшгүй хэрэгцээт бүтээгдэхүүн үйлчилгээг авч хэмнэлт хийн ажилласан.



 **ТӨРИЙН БАНК**
ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ



ЦЭВЭРЛЭГЭЭ

АЯН

Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа:

Нийгмийн хариуцлагын хүрээнд:



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2022 оны 3 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд Төрийн ордонд “Ногоон санхүүжилт-Бүс нутгийн чуулган” зохион байгуулагдсан. Энэхүү чуулганд Төрийн банк оролцож, ТоС хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй нийгмийн хариуцлагын ажлууд болон ногоон бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл өгч, ажилласны зэрэгцээ, банк санхүүгийн байгууллагууд уур амьсгалын өөрчлөлтийн стратеги, бодлогыг нэвтрүүлэх, боломж-сорилт, хамтын ажиллагааны талаар нэгдэн хэлэлцлээ. Тус чуулганаар 2030 он гэхэд арилжааны банкууд ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх зорилгыг дэвшүүлээ.

Жил бүрийн 6 дугаар сарын 2-ны өдөр тэмдэглэдэг “Банкны салбарын ажилтны өдөр”-ийг тохиолдуулан “Бид Банкир” аяны хүрээнд Монголын банкны холбоо, арилжааны банкууд, “Төгс хандлагаа өөрчилье” ТББ болон “Тэрбум мод сан” тус тус хамтран Богд ууланд 700 ширхэг шинэс модны суулгац тарьж “Банкируудын төгөл” байгууллаа.



Нийгмийн хариуцлагын хүрээнд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Зүрх мартаггүй төсөл”-д нэгдэн Төрийн банкны нийт ажилтнуудын дунд сайн үйлсийн аян зохион байгуулсан. Хандивын аянд банкны бүх газар, хэлтэс, нэгжүүдийн ажилтнууд оролцож нийт 11.5 сая төгрөгийг төслийн багт хүлээлгэн өгснөөр хоёр хүүхдийн хагалгааг хийлгэж бяцхан зүрхийг аварсан байна.

Цус сэлбэлтийн үндэсний төвтэй хамтран “Амьдрал бэлэглэе Цусаа өгөх өдөр” аяныг зохион байгуулж нийт 21 литр цус хандивлав.



Төрийн банкны нийт ажилтнууд өөрсдийн санаачилгаар хандивын аян өрнүүлж, Эх нялхсын хүүхдийн эрчимт эмчилгээний тасагт нэн шаардлагатай байсан “ХҮҮХДИЙН АМЬСГАЛ ДЭМЖИХ БАГАЖ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ”-ийг Япон улсаас захиалан авчирч эмнэлгийн хамт олонд хүлээлгэн өгөв.

Төрийн банк нь 2013 оноос эхлэн нийт ахмад настан харилцагч нартаа хүндэтгэл үзүүлэн “Хүндэтгэлийн аян”-ыг зохион байгуулж ирсэн. “Хүндэтгэлийн аян-2022” энэхүү аянаар уудам Монгол орныхоо өнцөг булан бүрд байгаа салбар, нэгжээрээ дамжуулан 21 аймаг, 7 дүүрэгт суугаа хамгийн өндөр настай 155 ахмад харилцагчдадаа хүндэтгэл үзүүлэв.



Нийслэлийн иргэдийн ундны усны эх үүсвэр болсон Туул голоо хамгаалах үйлсэд өөрсдийн үнэтэй хувь нэмрийг оруулж, төрийн болон төрийн бус байгууллагыг манлайлан, өөрсдийн оролцоогоор Туул голын сав газарт их цэвэрлэгээ хийсэнд талархал илэрхийлж, БОАЖЯ-ны харъяа Туул голын сав газрын захиргаанаас Төрийн банкны хамт олонд “ТАЛАРХАЛ”-ыг гардууллаа.



Нийт салбар, нэгжүүдийн дунд “Байгальд ээлтэй Төрийн банк аян”-ыг 2021 онд зарласны үр дүнд салбар, нэгжүүд хог ангилан хаях зориулалттай хогийн савыг байршуулан дахин боловсруулах цэгт тушаах, хуванцар сав, цаасан хайрцаг гэх мэт дахин ашиглах боломжтой зүйлсийг ашиглан цэцгийн сав, сандал, хог ангилах хогийн сав хийх зэрэг шинэ санаачилга гарган хэрэгжүүлж байна.



Төрийн банкнаас Монгол хүний оюуны чадамжийг Дэлхийд гайхуулж буй “Оюунлаг залуусаа дэмжих” аяны хүрээнд Монголын шатрын холбоо, Шатрын их мастер, Монгол Улсын Гавьяат тамирчин Ц.Батчулуун, Дэлхийн 3 удаагийн аварга, өсвөрийн шатарчин Д.Мөнхзултай хамтран ажиллаж байна.



Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран харилцагчдадаа цаг агаарын болзошгүй тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор Гялсбанк аппликейшны Мэдэгдэл хэсгээр нийт 52 удаагийн мэдээлэл хүргүүллээ.



“Би Багш” контент Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын заах арга барилыг сайжруулах, ирээдүй хойч үеийнхээ боловсролд хөрөнгө оруулах зорилгоор Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, “Боловсрол суваг” телевизтэй хамтран Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн шилдэг багш нарын оролцсон “Би багш” телевизийн контентыг хамтран хэрэгжүүлсэн.



“Хүрээлэн” төсөлтэй хамтран нэн ховордсон амьтад буюу мазаалай, цоохор ирвэс, цэн тогоруу, мануул, бүргэд, буга, тахь болон чоно гэсэн 8 төрөл зүйлийн амьтдыг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулж, байгалиа хамгаалах, хойч үеэ байгальд хайртай болгох зорилгоор 2019 онд 20 цуврал нэвтрүүлгийг үзэгчдийн хүртээл болголоо.

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд

Санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл өгөх

Санхүүгийн боловсрол

Иргэд, олон нийтэд

- "Санхүүгийн боловсрол гэж юу вэ?"
- "Хуримтлалын ашиг тус"

Танхим **55,418** иргэн

Олон нийтийн сүлжээ **609,100** иргэн

Сэдэв:
"Даатгал", "Санхүүгээ хэрхэн удирдах вэ", "Хуримтлал", "Орлого зарлагаа хэрхэн удирдах вэ", "Зээл хэрэгтэй юу?", "Залуу гэр бүлийн санхүү" ...

10 цуврал видео контент



Идэвхжүүлэлтийн арга хэмжээ

"Харилцагчийн өдөрлөг-2022" арга хэмжээ

10 аймаг

10 аймаг

Инкубатор төв

Ажилтан **123**

Сургагч багш **252**

Бүх салбар нэгжээр

Инкубацийн үйлчилгээ **6,453** бизнес эрхлэгч

Олгосон зээл **223** харилцагч **7.0** тэрбум төгрөг

Хамтын ажиллагаа 6 байгууллага

Сургалт

- Бизнесийг удирдах арга
- Манлайлагчийн ур чадвар
- Брэндиг болон маркетинг
- Орлого зардлын бүртгэл
- Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ
- Бизнес төлөвлөгөө боловсруулах
- Эрсдэлийн удирдлага
- Санхүүгийн удирдлага

ЖДҮГ, МҮХАҮТ, Баст хөтөлбөр, СЭЗИС, Гоолингоо ментор клуб, Эрүүл амьдралын жигүүр ТББ

Банкны Инкубатор төв болон хамтран ажиллагч байгууллагуудаар дамжуулан бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаа, санхүүгээ амжилттай удирдахад хэрэгцээт мэдлэг олгох, тэдний санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор нийт 6,453 бизнес эрхлэгчид сургалт зохион байгууллаа.

Банкнаас олон нийтийг хамарсан арга хэмжээг тохиолдуулан болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сувгаар дамжуулан 609,100 иргэнд санхүүгийн боловсрол олгох мэдээ, мэдээллийг хүргэж ажиллалаа.

Бидний ирээдүй болсон хүүхэд багачууд, залуусын санхүүгийн боловсрол, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, ирээдүйн банкны харилцагч дундаж давхаргын иргэдийг бэлтгэх, хуримтлал бий болгох дадал зуршилд суралцуулах зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургуулийн сурагч, оюутнуудад зориулсан "Санхүүч тагтаа" хөтөлбөрийг боловсруулж, Улаанбаатар орон нутгийн бүх салбар, тооцооны төвүүдээр дамжуулан хэрэгжүүлжээ. Хөтөлбөрийн хүрээнд нийт 42,825 оюутан, сурагчдад сургалт зохион байгууллаа.


Олон нийтэд санхүүгийн боловсрол түгээх, хуримтлалын ач тус, мөнгөө хэрхэн зөв зарцуулах талаар зөвлөгөө мэдээлэл өгөх 10 цуврал контентыг Монголбанкны эдийн засагчид, Германы Шпаркессэ банк болон олны танил санхүүгийн экспертүүдийг оролцуулан бэлтгэж, Төрийн банкны вэб сайт болон бусад социал сувгуудаар шат дараатай байршуулах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Тус контентод "Даатгал", "Санхүүгээ хэрхэн удирдах вэ", "Хуримтлал", "Орлого зарлагаа хэрхэн удирдах вэ", "Зээл хэрэгтэй юу?", "Залуу гэр бүлийн санхүү" зэрэг сэдвүүд багтсан болно.



■ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Төрийн банк нь Тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд олон улсын санхүүгийн байгууллага, дотоодын яамд болон ногоон, байгальд ээлтэй төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Тайлант хугацаанд ногоон таксономийн ангиллаар 494 зээлдэгчийн 25.0 тэрбум төгрөгийн ногоон зээлийн багцтай байсан бөгөөд нийт банкны системийн хэмжээний ногоон зээлийн багцын 7.9 хувийг эзэлж байна.



Төрийн банк нь системийн нөлөө бүхий банкуудаас хамгийн түрүүнд хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгож, засаглалын хувьд олон нийтийн компани болох эхлэлийг тавьсан. Хувьцаа гаргаж татан төвлөрүүлсэн 25.4 тэрбум төгрөгийг Тогтвортой хөгжилд чиглэсэн болон Нийгмийн дундаж давхаргад чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг санхүүжүүлэхэд бүрэн зарцуулав.



24/7

Бид тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэмэгдүүлэхийн зэрэгцээ одоо байгаа бүтээгдэхүүнийг илүү сайжруулан, харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлж амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

ЖИСА төслийн зээл буюу Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл

БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлж байгаа Агаар орчны бохирдлыг бууруулах өрхийн болон бизнесийн ногоон зээл

Банкны өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй хэрэглээний зээл болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл

Төслийн болон өөрийн эх үүсвэрийн санхүүжилттэй Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээл



Өөрийн эх үүсвэрийн санхүүжилттэй тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн

/2023.03.31-ний өдрийн байдлаар өссөн дүнгээрх олголт/



Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих” зээлийн бүтээгдэхүүнийг анх 2020 онд зах зээлд нэвтрүүлсэн ба нийт 1,036 эмэгтэй бизнес эрхлэгчдэд 29.7 тэрбум төгрөгийн зээлийг олгож тэдний бизнесийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа.



Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих, худалдан авах зээлийн хувьд банк хамгийн анх ToC холбоо болон GIZ төслийн байгууллагатай хамтран урьдчилгаа төлбөрийн татаас бүхий анхны туршилтын төслийг хэрэгжүүлж байсан бөгөөд өөрийн эх үүсвэрийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж нийтдээ 26 зээлдэгчид 1.8 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна.



Бид 2022 онд бүтээгдэхүүний нөхцөлийг илүү сайжруулан, тухайн сууцны эрчим хүчний хэмнэлтийн хувиас хамаарч зээлийн хүүг шатлалтай буюу эрчим хүчний хэмнэлт өндөр байх тусам зээлийн хүү буурдаг байхаар нөхцөлийг шинэчилсэн нь эрчим хүчний хэмнэлтийг илүү дэмжихэд чиглэсэн.



Банк өөрийн эх үүсвэрээр ногоон бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж, “Эко автомашины зээл”, Цахилгаан скүүтер, унадаг дугуйн зээлийн бүтээгдэхүүнийг 2019 оноос эхлэн гаргаж замын түгжрэл, утааг бууруулахад хувь нэмрээ оруулан ажиллаж нийтдээ 25 зээлдэгчид 0.49 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна.



Дундаж давхаргыг дэмжигч банкны цогц үйлчилгээг хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу “Сургалтын төлбөрийн зээл”-ийн бүтээгдэхүүнийг туршилтын хугацаанд зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд 2023 оны 2 сараас тус бүтээгдэхүүнийг “Боловсролыг дэмжих зээл” нэршлээр шинэчлэн нөхцөл, шаардлагыг сайжруулж зээлийн хэмжээ, хугацааг нэмэгдүүлсэн. Тус зээлийг сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсрол, дээд боловсрол

эзэмшихээр суралцаж буй иргэний сургалтын үйл ажиллагааг дэмжин сургалтын төлбөр төлөх, дотуур байрны төлбөр төлөх, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авахад зориулан олгодог бөгөөд 20 зээлдэгчийн 0.18 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.



Мөн Төрийн банк нь Дундаж давхаргын иргэдийг дэмжих зорилгоор тодорхой хугацаанд бичил бизнес буюу жижиглэнгийн худалдаа, өрхийн аж ахуй, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн Улаанбаатар хотын болон орон нутгийн иргэдийг Банкны бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулан санхүүгийн зөвлөгөө мэдээлэл өгөх замаар бизнесээ амжилттай удирдахад нь тодорхой хэмжээнд сургасны үндсэн дээр өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд зориулан Өрхийн бизнесийн зээлийг шинээр нэвтрүүлж 41 зээлдэгчид 1.2 тэрбум төгрөгийн зээл олголоо.



Дундаж давхаргыг дэмжих зорилгоор бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээд болон гарааны бизнес эхлүүлэхээр зорьж буй иргэн, аж ахуйн нэгжийг Банкны инкубацийн үйлчилгээнд хамруулан үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт болон эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулан гарааны бизнесийн зээлийг шинээр олгож эхэллээ. Тухайлбал, Улаанбаатар хотын болон орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг Банкны инкубацийн үйлчилгээнд хамруулан бизнесийн болон санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл өгөх, үйл ажиллагааны эхлэлийн болон өсөлтийн мөчлөгөөс тогтворжих түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлэн, технологийн шинэчлэлт хийх, тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх, үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгө бэлтгэх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан олгож буй зээл юм. Энэ хүрээнд 14 зээлдэгчид 1.37 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна.



Цаас болон цаг хугацааг хэмнэсэн Гялс зээлийн бүтээгдэхүүнийг 2020 оноос зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд нийт 2,361 зээлдэгчид 2.75 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд дунджаар нийт 4,722 цаг, 7,083 ш цаасыг хэмнэж ажиллалаа.



Хамтран ажиллаж буй ногоон төсөл, хөтөлбөрүүд:



Япон улсын Засгийн газар болон Монгол Улсын Сангийн Яамтай хамтарсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл” буюу JICA төслийн зээлийг байгаль орчныг хамгаалах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих гэсэн хоёр үе шаттайгаар олгодог. Дэд зээлийн төсөл нь техник технологийн ба арилжаа, санхүүгийн хувьд найдвартай байх, эрүүл ахуй, аюулгүй байдал, нүүлгэн шилжүүлэлт, байгаль орчны болон удирдлагын стандартад нийцсэн байх, түүнчлэн нүүлгэн шилжүүлэлтэд өртөх иргэдийн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар төслийг үр ашигтайгаар гүйцэтгэхээр байх бөгөөд 2006 оноос хойш жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих 76 төслийн 37.2 тэрбум төгрөгийн зээл, байгаль орчныг хамгаалах 10 төслийн 5.8 тэрбум төгрөгийн зээл, нийт 86 төслийн 43.0 тэрбум төгрөгийн зээлийг санхүүжүүлээд байна.



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос агаар болон орчны бохирдлыг бууруулах зорилгоор иргэд, аж ахуй нэгжүүд жилийн 2-3 хувийн хүүг төлөх, харин жилийн 9-13 хувийн хүүгийн татаасыг БОАЖЯ төлөх нөхцөлтэй зээл юм. Уг төслийн гол зорилго нь агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор цахилгаан халаагуур, дулаалгын материал, эко ариун цэврийн байгууламж, хүлэмж, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авах, мод бут ногоон байгууламж байгуулах, цахилгаан тээврийн хэрэгсэл худалдан авах, хийн халаалтын төхөөрөмж худалдан авах, суурилуулах, ногоон амины орон сууц худалдан авах, бариулах зэрэг зориулалтаар олгох бөгөөд бид 2020 оноос эхлэн хамтран хэрэгжүүлж ирсэн. “Байгальд ээлтэй хүүний хөнгөлөлттэй төсөл”-ийн зээлийн хувьд 288 зээлдэгчид 3.8 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй “Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн зээлийг дамжуулан зээлдүүлэх” буюу Тусгай хамгаалалттай бүс нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зээлийг Хэнтий, Хөвсгөл аймагт мөн Германы KFW байгууллагын санхүүжилтээр Архангай аймагт бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх буюу “Малын тоо толгойг нэмэгдүүлэхгүй байх” зорилго бүхий зээлийг олгон хамтран ажиллаж байна. Нийт 445 зээлдэгчид 3.7 тэрбум төгрөгийн зээлийг олгов.



ТоС Холбооноос Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан (НҮБ Хүүхдийн сан)-тай хамтран эрчим хүчний хэмнэлттэй Монгол гэрийн дулаалга, халаалтын CHIP багцыг зорилтот бүлэгт өгөх хөнгөлөлттэй ногоон зээлийг хэрэгжүүлэхэд Төрийн банк хамтран ажиллаж байна.




Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ

Байгаль орчин, нийгмийн бодлого, журмыг 2015 онд боловсруулан санхүүжилтийн асуудалдаа байгаль, орчин, нийгмийн асуудлыг авч үзэж, 50.0 сая төгрөгөөс дээш дүнтэй, 12 сараас дээш хугацаатай бизнесийн болон төслийн зээлүүдэд тус эрсдэлийн үнэлгээг тооцож эхэлсэн бөгөөд 2022 оноос зээлийн хэмжээг 100.0 сая төгрөг болгон нэмэгдүүллээ.

2015	Байгаль орчин, нийгмийн бодлого, журам	
2020	Байгаль орчин, нийгэм, жендэрийн эрх тэгш байдлын бодлого, журам	
2022	Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого	
2023	<ul style="list-style-type: none"> • Тогтвортой хөгжлийн журам • Тогтвортой хөгжлийн хорооны үйл ажиллагааны журам 	

Банк нь зээл олгох үйл ажиллагаандаа Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж ирсэн бөгөөд 2022 оны хувьд нийт 245 зээлдэгчийн 67.6 тэрбум төгрөгийн зээлд буюу бизнесийн зориулалтаар олгосон зээлийн 61 хувьд тус үнэлгээг хийж гүйцэтгэлээ. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээгээр өндөр болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн зээлүүдэд эрсдэл бууруулах зөвлөмж өгч, үүргээ хэрэгжүүлж буй эсэхэд зайнаас болон газар дээрх хяналтыг гүйцэтгэн ажиллаж байна.



БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээ, салбараар /2022 он/



Тогтвортой хөгжилд чиглэсэн бусад бүтээгдэхүүний талаар



Төрийн Банкны хэрэгжүүлж буй “Эко боловсрол олгох аян”-ы хүрээнд Хүрээлэн төсөлтэй хамтран нэн ховор амьтдын зурагтай ЭКО картыг 2020 онд зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд өссөн дүнгээр нийт 75,722 ш борлуулж хураамжаас олсон орлогын 1'000 төгрөгийг нэн ховордсон амьтдыг хамгаалах санд шилжүүлж байгаль, ан амьтдаа хамгаалахад хувь нэмэр оруулж байна.



Бид 2022 онд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан Юнионпэй карт гаргагч байгууллагын Travel Mate Asia хөнгөлөлт урамшуулалд хамрагдах боломжтой, аяллын “Save green” кредит картыг зах зээлд нэвтрүүлж, нийт 86 ш карт олгоод байна.




Миний Монгол Олон Улсын карт буюу 21 аймгийн үзэсгэлэнт байгалийн зурагтай картыг 2021 оноос харилцагчдадаа санал болгож эхэлсэн бөгөөд нийт 6,908 ш карт олгоод байна. Тус картын хураамжийн орлогоос 1,000 төгрөгийг тухайн аймгийн байгаль хамгаалах санд хуримтлуулж байна.



Төрийн банк “Дундаж давхаргыг дэмжигч, Үндэсний тэргүүлэгч банк” байх зорилтын хүрээнд “Эрүүл амьдралын жигүүр” ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийг 2022 онд байгуулан Дундаж давхаргын иргэдэд хуримтлалын зуршил бий болгож, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд гадаад, дотоодын гэрээт эмнэлгүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамрагдах боломжийг бүрдүүлсэн “Эрүүл иргэн” хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд 2022 оны эцсийн байдлаар 3,079 иргэн төгрөгийн хуримтлал үүсгээд байна.

■ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ



Монголын Тогтвортой Санхүүжилтийн холбоо, Монголбанк, Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран “Тогтвортой санхүүжилтийн хэрэгжилтийн үнэлгээ”-г 2016 оноос эхлэн жил бүр гишүүн байгууллагууддаа хийж ирсэн бөгөөд Төрийн банк ХК нь 2022 онд өмнөх оны үр дүнгээ ахиулан “А” буюу “Бүрэн тогтолцоотой” /Consolidating/ үнэлгээ авлаа.



Бид Тогтвортой санхүүжилтийн холбоонд хагас жил бүр сайн дурын үндсэн дээр Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн дагуу хийгдсэн ажлын тайланг тогтмол тайлагнаж байна. Уг тайлангаар Тогтвортой санхүүжилтийн менежментийн систем, Байгаль орчин ба нийгмийн менежментийн систем, зээлийн байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал, ногоон зээл олгосон байдал болон ТоС-ийн 8 зарчмын дагуу хийгдсэн ажлуудын хэрэгжилтийн мэдээллийг тайлагнадаг.



Монгол Улсын Санхүүгийн Тогтвортой байдлын зөвлөлөөс ногоон зээл, ногоон хөрөнгө оруулалтын шалгуур үзүүлэлт бүхий “Ногоон таксономи”-г 2019 онд баталсан бөгөөд банк тус 8 ангиллын дагуу олгосон ногоон зээлийн олголт, төлөлт, үлдэгдлийн мэдээг улирал бүр Монголбанканд тогтмол тайлагнан ажиллаж байна.



Төрийн банк олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор Байгаль орчин, нийгэм засаглалын 2022 оны тайланг зохицуулагч байгууллагуудаас гаргасан удирдамжийн дагуу Монголын Хөрөнгийн биржид хүргүүлж ажиллалаа.



📞 1800-1881

🌐 www.statebank.mn

📘 /StatebankMN

📺 /StatebankMN